



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/96/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15



## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021-09-23 № 129

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.ЗОЛГЭРЭЛ ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Чулуунхороот сумын ИТХ нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 84,0 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020042



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,614,770.00</b>	<b>4,364,223.00</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	749,453.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		749,453.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,614,770.00	3,614,770.00
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	3,614,770.00	3,614,770.00
35420	Аж ахуйн материал	3,614,770.00	3,614,770.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,249,692.99</b>	<b>5,045,366.19</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,249,692.99	5,045,366.19
392	Биет хөрөнгө	6,249,692.99	5,045,366.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,683,700.00	6,039,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,567,540.08)	(2,013,266.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,808,980.00	2,808,980.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,695,446.93)	(1,946,146.97)
39217	Ном	20,000.00	156,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>9,864,462.99</b>	<b>9,409,589.19</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>749,453.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	749,453.00
413	Өглөг	-	749,453.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		749,453.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,864,462.99</b>	<b>8,660,136.19</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,864,462.99	8,660,136.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,303,966.00	5,303,966.00
51101	Өмч: - төрийн	5,303,966.00	5,303,966.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,560,496.99	3,356,170.19
51210	Өмнөх үеийн үр дүн	4,560,496.99	4,560,496.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,204,326.80)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,864,462.99</b>	<b>9,409,589.19</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>60,580,300.00</b>	<b>262,333,600.00</b>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,580,300.00	262,333,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	201,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,580,300.00	61,333,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,580,300.00	61,333,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-



1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	56,637,320.12	263,537,926.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,637,320.12	263,537,926.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,340,449.05	261,954,829.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,609,028.14	47,829,199.15
210101	Үндсэн цалин	31,439,032.54	40,837,999.15
210104	Урамшуулал	5,169,995.60	6,991,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,895,915.79	5,375,454.89
210201	Тэтгэврийн даатгал	2,653,277.77	3,554,172.66
210202	Тэтгэмжийн даатгал	65,626.23	475,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,135.80	379,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	250,615.40	95,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	615,260.59	871,082.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	7,012,115.00	4,538,579.00
210401	Бичиг хэрэг	839,180.00	838,780.00
210402	Тээвэр, шатахуун	5,586,935.00	3,304,799.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,000.00	-
210404	Ном, хэвлэл	156,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	190,000.00	395,000.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	280,000.00	-
210604	Урсгал засвар	280,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,786,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	1,786,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,697,390.12	204,011,596.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,519,800.00	202,671,270.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,177,590.12	1,340,326.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	296,871.07	1,583,096.96
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	296,871.07	1,583,096.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	296,871.07	1,583,096.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,942,979.88	(1,204,326.80)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,942,979.88	(1,204,326.80)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	60,580,300.00	262,333,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,580,300.00	262,333,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	201,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,580,300.00	61,333,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,580,300.00	61,333,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-



2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	60,580,300.00	262,333,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,580,300.00	262,333,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,283,428.93	260,750,503.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,609,028.14	47,829,199.15
210101	Үндсэн цалин	31,439,032.54	40,837,999.15
210104	Урамшуулал	5,169,995.60	6,991,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,895,915.79	5,375,454.89
210201	Тэтгэврийн даатгал	2,653,277.77	3,554,172.66
210202	Тэтгэмжийн даатгал	65,626.23	475,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,135.80	379,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	250,615.40	95,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	615,260.59	871,082.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	8,682,885.00	4,674,579.00
210401	Бичиг хэрэг	1,299,980.00	838,780.00
210402	Тээвэр, шатахуун	5,486,935.00	3,304,799.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,000.00	-
210404	Ном, хэвлэл	156,000.00	136,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,499,970.00	395,000.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,499,700.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,489,800.00	-
210602	Тавилга	729,900.00	-
210604	Урсгал засвар	280,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,786,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	1,786,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,749,900.00	202,671,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,749,900.00	202,671,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	296,871.07	1,583,096.96
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	296,871.07	1,583,096.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	296,871.07	1,583,096.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	---



C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,303,966.00	0.00	4,560,496.99	0.00	9,864,462.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,303,966.00	0.00	4,560,496.99	0.00	9,864,462.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,303,966.00	0.00	4,560,496.99	0.00	9,864,462.99
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,303,966.00	0.00	4,560,496.99	0.00	9,864,462.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,303,966.00	0.00	4,560,496.99	0.00	9,864,462.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,204,326.80	0.00	-1,204,326.80
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,303,966.00	0.00	3,356,170.19	0.00	8,660,136.19

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,580,300.00	60,003,428.93	61,333,600.00	59,750,503.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,580,300.00	60,003,428.93	61,333,600.00	59,750,503.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,580,300.00	60,003,428.93	61,333,600.00	59,750,503.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,609,029.00	36,609,028.14	47,568,300.00	47,829,199.15
210101	Үндсэн цалин	31,439,033.00	31,439,032.54	40,576,200.00	40,837,999.15
210104	Урамшуулал	5,169,996.00	5,169,995.60	6,992,100.00	6,991,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,895,918.00	3,895,915.79	5,958,100.00	5,375,454.89
210201	Тэтгэврийн даатгал	2,653,278.00	2,653,277.77	4,056,000.00	3,554,172.66
210202	Тэтгэмжийн даатгал	65,627.00	65,626.23	474,400.00	475,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,136.00	311,135.80	380,100.00	379,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	250,616.00	250,615.40	96,000.00	95,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	615,261.00	615,260.59	951,600.00	871,082.23



Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	8,682,885.00	8,682,885.00	6,460,100.00	3,841,079.00
210401	Бичиг хэрэг	1,299,980.00	1,299,980.00	571,000.00	673,780.00
210402	Тээвэр, шатахуун	5,486,935.00	5,486,935.00	2,788,100.00	2,636,299.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,000.00	240,000.00	300,000.00	-
210404	Ном, хэвлэл	156,000.00	156,000.00	1,451,000.00	136,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,499,970.00	1,499,970.00	1,350,000.00	395,000.00
2105	Нормативт зардал	-	-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,219,700.00	3,219,700.00	-	-
2107	Томилолт, зочны зардал	1,786,000.00	1,786,000.00	1,107,100.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	1,786,000.00	1,786,000.00	1,107,100.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,000.00	60,000.00	240,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	60,000.00	240,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,326,768.00	5,749,900.00	-	2,504,770.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,326,768.00	5,749,900.00	-	2,504,770.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	60,580,300.00	60,580,300.00	61,333,600.00	61,333,600.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	59,580,300.00	59,580,300.00	60,333,600.00	60,333,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	59,580,300.00	59,580,300.00	60,333,600.00	60,333,600.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	-
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	-
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	-
14	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	-	-
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	-
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	2.00	2.00	2.00	2.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан				-



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	201,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	201,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	201,000,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	833,500.00
210401	Бичиг хэрэг	-	165,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	668,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	200,166,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	200,166,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	200,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	200,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Золгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ноос 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чулуунхороот сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.



Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чулуунхороот сумын ИТХ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Чулуунхороот сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 56,637.3 мянган төгрөгөөс тооцон 1,132.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,270.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 454.9 мянган төгрөгөөр буюу 4,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдлийн дансны бууралттай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	749.4	749.4
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	3,614.8	3,614.8	0
Үндсэн хөрөнгө	10,512.7	9,004.8	-1,507.9
Элэгдэл	-4,263.0	-3,959.4	303.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,864.5</b>	<b>9,409.6</b>	<b>-454.9</b>
Өр төлбөр		749.4	749.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,864.4	8,660.1	-1,204.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9,864.5</b>	<b>9,409.4</b>	<b>-454.9</b>



Авлага дансны үлдэгдэл 749.4 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,004.8 мянган төгрөг болж 1,507.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Чулуунхороот сумын ИТХ-н 2020.07.25 №17 тогтоолоор 1,643.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 749.4 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалингаас татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,660.1 мянган төгрөг болж 1,204.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Чулуунхороот сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 201,753.3 мянган төгрөгөөр буюу 4,3 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь хэлмэгсдийн ар гэрт олгох тэтгэмжийн санхүүжилт 200,0 сая төгрөгөөр, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нэмнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 206,900.6 мянган төгрөгөөр буюу 4,7 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт хэлмэгсдийн ар гэрт олгосон 200,0 сая төгрөгийн тэтгэмж, цалин хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь хэлмэгсдийн ар гэрт олгосон тэтгэмж болон Засгийн газраас цалин хөлс нэмсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 61,333.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 61,333.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагч нь хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /код-70105/ хөтөлбөрийн 1 /код-80101/ арга хэмжээг санхүүжүүлэхээр 61,333.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 61,333.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 59,750.5 мянган төгрөгийг зарцуулж 1,583.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 59,750.5 мянган төгрөг буюу 97,4 хувьтай байгаа нь Томилолт зочны зардлыг 907.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 67.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.



Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь цар тахалтай холбоотой томилолт зочны зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны орлогыг дээд шатны төсвийн захирагчаас олгосон 1,000.0 мянган төгрөг, хэлмэгсдийн ар гэрт олгох тэтгэмжийн санхүүжилт 200,000.0 мянган төгрөгийн орлогоор бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардал буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 1,000.0 мянган төгрөг зарцуулж, хэлмэгсдийн ар гэрт 200,000.0 мянган төгрөгийн олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 126 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 9 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 2,800.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,800.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал гараагүй тул залруулга хийгдээгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 61,333.8 мянган төгрөгийн, худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй 2,050,7 мянган төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 749,5 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Чулуунхороот сумын ИТХ нь 61,333.6 мянган төгрөгийн 9 мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан нь Шилэн дансны 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн



төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор", 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.7 дах "байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд хийсэн 2,050.7 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.5 дахь хэсэгт "... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь заалт Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтны цалингийн орлогоос нийт 749.5 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2 дахь "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Чулуунхороот сумын ИТХ-ын 2020 оны жили эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/96/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Чулуунхороот сумын ИТХ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд хийсэн 2,050.7 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй	2,050.7		Дарга Нягтлан бодогч	Б.Золгэрэл Г.Одонтунгага
2	Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг тулган шалгахад нийт 137 мэдээ байршуулах ёстойгоос тухайн жилийн төсөв, хөрөнгө оруулалт, орон тооны мэдээлэл зэрэг 3 мэдээллийг хоцроон мэдээлсэн байна	61,333.8		Дарга	Б.Золгэрэл
	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтны цалингийн орлогоос нийт 749.5 мянган төгрөгийн татвар суутгасан	745.9		Дарга Нягтлан бодогч	Б.Золгэрэл Г.Одонтунгага
<b>ДҮН</b>		<b>64,134.0</b>			